



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/580

Алтай хот


Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн багш, сурагчид, албан хаагчид, байгууллагыг урамшуулах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.7. дахь заалт, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28¹.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөрийн 7 дугаар зүйлийн 7.3.2.1, 7.3.1.6 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсэг, аймгийн Засаг даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлын 2022 оны 35 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөрийн хүрээнд Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн багш, сурагчид, албан хаагчид, байгууллагуудыг урамшуулах журмыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дугаар сарын 15-ны өдрийн 1580 дугаар
захирамжийн хавсралт

**ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТАД АМЖИЛТ
ҮЗҮҮЛСЭН БАГШ, СУРАГЧИД АЛБАН ХААГЧИД,
БАЙГУУЛЛАГУУДЫГ УРАМШУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28¹.1.3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1.2, 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалт “Боловсролын чанарыг сайжруулах” хөтөлбөрийн 7 дугаар бүлгийн 7.3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэл болгов.

1.1. Говь-Алтай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, тухайн хичээлийн жилийн Элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр амжилт үзүүлсэн багш, сурагчид болон тэдгээрт дэмжлэг үзүүлж ажилласан албан хаагчид, байгууллагуудыг урамшуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн, үнэлгээг үндэслэн урамшуулалд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, урамшуулал олгоход энэхүү журмыг баримтална.

Хоёр. Урамшуулалд нэр дэвшүүлэх, урамшуулах хэмжээ

2. Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн багш, суралцагчид, Боловсрол, шинжлэх ухааны газар, сургуулийн хамт олныг нэр дэвшүүлж зөвхөн мөнгөн хэлбэрээр урамшууллыг олгоно.

2.1. Багш нар

2.1.1. Элсэлтийн ерөнхий шалгалтад нийгмийн ухааны багш 10-аас дээш сурагч бэлтгэн оролцуулаад 600-аас дээш онооны дундаж үнэлгээ авахуулсан бол 10,0-20,0 хүртэлх сая төгрөгөөр, байгалийн ухааны багш 10-аас дээш сурагч бэлтгэн оролцуулаад 580-аас дээш онооны дундаж үнэлгээ авахуулсан бол 10,0-20,0 хүртэлх сая төгрөгөөр багийн (багш-сурагч) амжилтыг үнэлж урамшуулал олгоно. Энэхүү амжилтыг 2-оос дээш жил гаргаж, амжилтаа тогтмол хадгалж, өсгөсөн багшид 50,0 хүртэлх сая төгрөг буюу орон сууцны урьдчилгаа олгоно.

2.1.2. Хичээл тус бүр дээр бэлтгэсэн сурагчаа 800 оноонд хүргэсэн багшид 7,0 сая хүртэлх¹, 750-аас дээш оноо авахуулсан бол 3,0 сая хүртэлх², 700-гаас дээш оноо авахуулсан багшид 2,0 сая хүртэлх, 650-иас дээш оноо авхуулсан багшид 1,0 сая хүртэлх төгрөгийн урамшуулал олгоно.

2.1.3. Олон улс, улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд өөрөө болон бэлтгэсэн сурагч нь 1-3 дугаар байрт шалгарсан багш нарт 3,0-1,0 сая төгрөгийн урамшуулал олгоно.

2.

2.2. Сурагчид

2.2.1. Сүүлийн 3 жил тойргийн сургуульдаа суралцсан элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан сурагчид тухайн жилийн сургалтын төлбөрийг 100 хувь олгоно.

2.2.2. Шалгалтын үнэлгээгээр дотоодын их, дээд сургуульд элсэн суралцаж буй 750-аас дээш оноо авсан сурагчид тухайн жилийн дундаж сургалтын төлбөрийн 70 хүртэлх хувь, 700-гаас дээш оноо авсан сурагчид 50 хүртэлх, 650-иас дээш оноо авсан бол 20 хүртэлх хувийн төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.

хувиар төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.

2.3. Байгууллага, хамт олон, захирал, сургалтын менежер

2.3.1. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр аймагтаа 1 дүгээр байр эзэлсэн сургуулийн хамт олонд 10,0 сая хүртэлх, 2 дугаар байр эзэлсэн сургуулийн хамт олонд 7,0 сая хүртэлх, 3 дугаар байр эзэлсэн сургуулийн хамт олонд 5,0 сая хүртэлх, улсын дундаж онооноос дээш үнэлэгдсэн бусад сургуулийн хамт олонд 3,0 сая хүртэлх³ төгрөгийг тус тус олгох бөгөөд хамт олны шагналын 20 хувь нь сургуулийн захиралд ногдоно.

2.3.2. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр аймагтаа 1 дүгээр байр эзэлсэн сургуулийн сургалтын менежер тус бүрт 3,0 сая хүртэлх, 2 дугаар байр эзэлсэн сургуулийн сургалтын менежер тус бүрт 2,0 сая хүртэлх, 3 дугаар байр эзэлсэн сургуулийн сургалтын менежер тус бүрт 1,0 сая хүртэлх, улсын дундаж онооноос дээш үнэлэгдсэн бусад сургуулийн сургалтын менежер тус бүрт 0,5 сая хүртэлх төгрөгийн урамшууллыг олгоно.

2.3.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноогоор улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн сумдын Засаг дарга нарыг аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний заалтыг үндэслэн жилийн эцэст урамшуулал олгоно.

2.3.4. Боловсрол, шинжлэх ухааны газарт тухайн жилийн урамшууллын 5 хүртэлх хувийг олгож хамт олны хурлаар шийдвэрлэнэ. Газрын даргад тухайн урамшууллын 45 хүртэлх хувийг олгож болно.

Гурав. Санхүүжилт

3.1. Орон нутгийн төсөв

3.2. "Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөр буюу аймгийн Орон нутгийн хөгжлийн сан

3.3. Бусад эх үүсвэр


Дөрөв. Элсэлтийн ерөнхий шалгалтын урамшуулал гардуулах

4.1. Элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээгээр урамшуулал гардуулах үйл ажиллагааг жилд нэг удаа буюу багш нарын баярыг угтаж 9 дүгээр сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулна.

Тав. Хариуцлага

5.1. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр улсын дундаж онооноос доогуур үнэлэгдсэн сумын Засаг даргад хариуцлага тооцох асуудлыг аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хүрээнд шийднэ.

5.2. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр улсын дунджаас доогуур үнэлгээтэй сургуулийн захиралд хариуцлага тооцох саналыг тухайн шатны Засаг даргад Боловсрол, шинжлэх ухааны газраас хүргүүлнэ.



3.

5.3.Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр хангалтгүй оноо авсан багш нарт сургуулийн захирал хариуцлага тооцно.

5.4.Элсэлтийн ерөнхий шалгалтад аймгуудаас хангалтгүй байр эзэлж 15-аас хойш байр эзэлсэн тохиолдолд Боловсрол, шинжлэх ухааны газрын даргад аймгийн Засаг дарга хариуцлага тооцно.

5.5.Хариуцсан судлагдахуун нь өмнө хүрсэн түвшингөөс оноо буурсан улсын дундаж онооноос доогуур үнэлэгдсэн Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүдэд Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга хариуцлага тооцно.

Зургаа. Бусад

6.1.Тухайн багшийн хувь амжилт болон багийн амжилт давхацсан тохиолдолд хамгийн үнэлгээ өндөртэй урамшууллыг нь олгох бөгөөд давхацуулж урамшууллыг олгохгүй.

6.2.Энэхүү журамд тусгагдаагүй бусад асуудлыг “Боловсролын чанарыг сайжруулах” хөтөлбөр болон Монгол Улсын бусад хууль тогтоомжуудын заалтаар зохицуулна.

__оОо__

